



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 08 сарын 12 өдөр

Дугаар А/374

Чингис хот

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1-ийн "а", Төсвийн тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.2.20, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. "Коронавируст халдвар /ковид-19/-аас сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах түр журам"-ыг хэрэгжүүлэх зорилгоор Улаанбаатар хотоос тус аймаг руу нэвтрэх иргэдийг бүртгэх, шинжилгээ авах цэг, тээврийн хэрэгслийн хөдөлгөөнд хяналт тавих үүрэг бүхий Цэнхэрмандал сумын "Дэлүүн болдог" постод 2021 оны 7 дугаар сарын 02-ны өдрөөс 2021 оны 8 дугаар сарын 01-ний өдрийг хүртэл 30 хоногийн хугацаанд ажиллаж буй 12 алба хаагчдын байр, хоол, автомашины шатахууны зардлыг нэгдүгээр, аймгийн төвд ажиллаж буй "Тусгаарлах байр"-д 2021 оны 5 дугаар сарын 25-аас 2021 оны 8 дугаар сарын 01-ний хүртэл 68 хоногийн хугацаанд харуул хамгаалалтын үүрэг гүйцэтгэж буй алба хаагчдын хоол, аймгийн "Шуурхай штаб"-т үүрэг гүйцэтгэж буй жижүүрийн алба хаагчдын хоол, бичиг хэргийн зардлыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлж ажиллахад шаардагдах 21.525.000 (хорин нэгэн сая таван зуун хорин таван мянга) төгрөгийг аймгийн Гамшгийн эрсдэлийг бууруулах сангаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (С.Нямдаваа)-д зөвшөөрсүгэй.

3. Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Ц.Чогсомжав)-д даалгасугай.


ЗАСАГ ДАРГА



Ц.ИДЭРБАТ

231011786

Аймгийн Засаг даргын 2021 оны
.. дугаар сарын .. өдрийн ..
дугаар захирамжийн нэгдүгээр хавсралт



ЗАРДЛЫН ТООЦОО

Байгууллагын нэр	ЗАРДЛЫН НЭР ТӨРӨЛ			Дүн
	Шатахууны зардал	Байрны зардал	Хоолны зардал	
Цагдаагийн газар	555.000	900.000	7.200.000	8.655.000
ДҮН	555.000	900.000	7.200.000	8.655.000

Аймгийн Засаг даргын 2021 оны
... дугаар сарын ... өдрийн ...
дугаар захирамжийн хоёрдугаар хавсралт



ЗАРДЛЫН ТООЦОО

Байгууллагын нэр	ЗАРДЛЫН НЭР ТӨРӨЛ			Дүн
	Бичиг хэргийн зардал	Шуурхай шатбын хоолны зардал	"Тусгаарлах байр"-ны хоолны зардал	
Онцгой байдлын газар	350.000	3.000.000	9.520.000	12.870.000
ДҮН	350.000	3.000.000	9.520.000	12.870.000